



УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2020 оны 01 сарын 24-өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

I ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Улсын онцгой комиссийн I хурал 2020 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн 16.30 цагт Төрийн ордон дахь Шадар сайдын ажлын өрөөнд 80 хувийн ирцтэй хуралдав.

Хурлыг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссийн дарга
Ө.Энхтувшин даргалж, холбогдох үүрэг, даалгаврыг өгев.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

1. Шинэ коронавирусийн халдвартын болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, цаашид шийдвэрлүүлэх тулгамдсан асуудлын талаар Эрүүл мэндийн сайд, Улсын онцгой комиссийн гишүүн Д.Сарангэрэлийн мэдээллийг сонсов.

ШИЙДВЭРЛЭССЭН НЬ:

Нэг Эрүүл мэндийн сайд,

Улсын онцгой комиссийн гишүүн Д.Сарангэрэлд;

1.1. Эмнэлгийн тусламж үйлчилгээний бэлэн байдлыг хангах, эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг бүрэн хангаж, шаардлагатай тохиолдолд резидент эмч нарыг бэлэн байдалд байлгахыг;

1.2. Иргэд, олон нийтэд хандсан цаг үеийн нехцел байдлын талаарх мэдээллийг нэг цэгээс, бодитой, хүртээмжтэй хүргэх;

Хоёр Боловсрол, соёл, шинжлэх ухаан,
спортын сайд Ё.Баатарбилэгт.

2.1. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааг өмчийн хэлбэр харгалзахгүйгээр 2020 оны 1 дүгээр сарын 27-ны өдрөөс 3 дугаар сарын 2-ны өдрийг хүртэл түр хаахыг;

2.2. Тогтоосон хугацаанд суралцагчдад сургалтын хөтөлбөрийн дагуу мэдлэг олгох ажлыг цахим хэлбэрээр зохион байгуулах арга хэмжээ авахыг;

Гурав. Сангийн сайд Ч.Хүрэлбаатарт;

3.1. Шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх, эмнэлгийн тусламж үйлчилгээний бэлэн байдлыг хангахад шаардагдах санхүүжилтын асуудлыг шуурхай шийдвэрлэхийг;

Дөрөв Зам, тээврийн хөгжлийн сайд,

Улсын онцгой комиссын гишүүн Б.Энх-Амгаланд:

4.1. Эрүүл мэндийн яам, Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас гаргасан зөвлөмжийн дагуу нийтийн тээврийн хэрэгслийн эрүүл ахуй, халдварт судлалын нөхцөлийг сайжруулж, холбогдох байгууллагуудтай хамтран ажиллахыг;

Тав Аймаг, нийслэлийн Засаг дарга,

Онцгой комиссын дарга нарт.

5.1. Олон нийтийг хамарсан төрөл бүрийн арга хэмжээ зохион байгуулахыг турхугацаа гар хязгаарлахыг;

Зургаа, Эрүүл мэндийн сайд,

Улсын онцгой комиссын гишүүн Д.Сарангэрэл,

Хил хамгаалах ерөнхий газрын дарга,

Улсын онцгой комиссын гишүүн,

бригадын генерал Ж.Бямбасурэн нарт.

6.1. БНХАУ-тай хиллэдэг хилийн боомтуудаар зорчигч тээврийн хэрэгслээр болон явганаар зорчих иргэдийн хөдөлгөөнийг түрхугацаа гар хязгаарлах асуудлыг холбогдох байгууллагуудтай хамтран судлаж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлүүлэхийг;

Долоо. Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга,

Улсын онцгой комиссын гишүүн Н.Цагаанхүүд:

7.1. Хилийн хяналтыг сайжруулж, тандалт судалгааг эрчимжүүлж, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулахыг;

Нийм. Засгийн газрын Хэвлэл мэдээлэл,

олон нийттэй харилцах хэлтсийн дарга,

Улсын онцгой комиссын гишүүн Б.Ганзоригт:

8.1. Эрүүл мэндийн яам, Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас гаргасан зөвлөмжийн дагуу иргэдэд чиглэсэн эрүүл мэндийн мэдээлэл, сурталчилгааг олон нийтийн мэдээллийн хэрэгслүүдээр дамжуулан шуурхай нийтэлж, нэвтрүүлэхийг тус тус үүрэг болгов.

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД,
УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ДАРГА

Ө.ЭНХТУВШИН

